

Үнэт цаасыг арилжаалахад зуучлах мэргэжлийн байгууллагын тухай мэдээлэл:

Үнэт цаасыг арилжаалахад зуучлах мэргэжлийн байгууллага нь СИ СИ ПИ ХХК хувьцаа гаргахад ерөнхий хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үзүүлж байна.

СИ СИ ПИ ХХК нь үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргагчдыг шинээр үнэт цаас гаргахад зах зээлд шаардагдах шинжилгээ хийх, хяналт явуулах, зөвлөгөө өгөх, зуучлан борлуулах, худалдан авах, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох зэрэг үйл ажиллагааг хийж гүйцэтгэдэг.

Монгол улсад хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа цаашлаад санхүүгийн зөвлөх компанийн орон зай дутагдаж байгаа өнөө үед цаг үеэ олсон, шинэлэг, ур чадвар бүхий Хөрөнгө оруулалтын зөвлөх Си Си Пи ХХК (ССР) 2006 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

ССР нь дотоодын компаниудад үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Монголын болон олон улсын хөрөнгийн биржээс санхүүжихэд зөвлөгөө өгч туслахын зэрэгцээ олон улсын болон дотоодын стратегийн түншүүдтэйгээ хамтран компаниудад мэргэжлийн санхүүгийн үйлчилгээг хүргэж харилцагчдынхаа хөрөнгийг өсгөхөд харамгүй туслалцаа үзүүлэхэд бэлэн байна.

Бид гадаад, дотоодод хөрөнгө оруулалтын банк, стратегийн зөвлөхийн чиглэлээр ажиллаж байсан нэр хүндтэй их сургууль төгссөн чадварлаг багийг бүрдүүлэн ажиллаж байна.

Бидний зорилго

ССР нь Монголын өсч яваа эдийн засгийн хэрэгцээг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг хуваарилах, удирдах ажлыг гүйцэтгэхэд ерөнхий санхүүгийн зөвлөхөөр ажиллах болно. ССР ХХК-ийн хэтийн зорилго бол санхүүгийн зөвлөгөө, сангийн удирдлага, үнэт цаасны андеррайтинг, байршуулалт зэрэг санхүүгийн зөвлөгөөний үзүүлдэг тэргүүлэгч компани болох явдал юм. ССР нь харилцагч нартаа ашигтай санхүүгийн шийдлүүдийг мэргэжлийн өндөр түвшинд хүргэхэд зуучлан зөвлөх болно.

ССР-ийн зорилго дотоодын компаниудыг дэлхийн түвшний байгууллага болоход нь өсөлт, хөгжлийнхөө хэрэгцээг удирдах шинэлэг, үр ашигтай санхүүжилтийн шийдлүүдийг хүргэж туслах явдал юм.

ССР монгол улсын эдийн засагт оюуны хөрөнгө оруулалтыг түлхүү хийж өндөр хувь нэмэр оруулах төдийгүй нийт бизнесийн хүрээнийхний өсөлт, хөгжилтөд ч хувь нэмрээ оруулах болно.

Бидний туршлага

ССР нь байгууллагын бонд андеррайтинг, үнэт цаасны зах зээлийн төрөл бүрийн хэрэгслүүдийн судалгаа, эдийн засгийн үндэслэл гаргах, компанийн санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааг нь дүгнэх, үнэт цаас болон хөрөнгө оруулалтын стратеги, стратегийн өсөлт хөгжил, ашгийн өсөлтийн удирдлагын чиглэлээр зөвлөх үйлчилгээг үзүүлж байсан туршлагатай

Ажлын туршлагын хувьд Анод банкинд Монголын Үнэт Цаасны хорооноос (одоогийн Санхүүгийн зохицуулах хороо) андеррайтингийн эрхийн лицензийг авч анхны хөрөнгө оруулалтын банкны суурийг тавиж байсан, MCS Электроникс ХХК болон Говь ХК, Анод Банкны нийт 5.6 тэрбум төгрөгийн бондыг хөрөнгийн зах зээл дээр гаргах ажлыг амжилттай удирдаж байсан. МСС ХХК-ийн андеррайтингийн эрхийн лицензийг авч байсан.

Канад улсын Айвенхоу Майнз ХХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах тухай, Айвенхоу Майнзын хувьцааг хөрвүүлж MDR болгон гаргах төслийн удирдагчаар ажиллаж байсан. 2006 оны 11 сард Техник Импорт ХК-д санхүүгийн зөвлөхөөр ажиллаж нийт 560 сая төгрөгийн санхүүжилтын асуудлыг шийдвэрлэсэн.

2003-2006 онуудад Говь ХК, Сүү ХК, Хадгаламжийн банк ХХК зэрэг томоохон төрийн өмчийн газруудын хувьчлалд зөвөлгөө өгч төслийг удирдан оролцож байсан.

2007 оны 6 сард Юнигаз ХХК-ийн 700 000 ам.долларын биет бондыг гаргасан.